



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 11/556

Улаанбаатар хот

Багахангай дүүргийн Цагдаагийн хэлтсийн
хөрөнгийг данснаас дансанд шилжүүлэн
бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан 175,750.0 /нэг зуун далан таван мянга долоон зуун тавин/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Багахангай дүүргийн Цагдаагийн хэлтэс /Б.Нямсүрэн/-т зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Багахангай дүүргийн Цагдаагийн хэлтэс /Б.Нямсүрэн/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050001463

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 12 сарын
11 өдрийн 0156-р тушаалын хавсралт

Данснаас дансанд шилжүүлэн бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Багахангай дүүргийн Цагдаагийн хэлтэс

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үнэ		Дансны нэр	
					Нэгжийн үнэ	Нийт үнэ	Шилжүүлэх данс	Бүртгэх данс
1	Угаалгын машин	2006	ш	1	175,750.00	175,750.00	Тавилга эд хогшил	Машин тоног төхөөрөмж
Машин тоног төхөөрөмжийн дүн						175,750.00		